ДӨЛГӨӨН ХАЙРХАН УУЛ
**АУДИТ ХХК**
Нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн
хөндлөнгийн хяналтын байгууллага

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороолол
Ногоон нуур гудамж, 101 барилгын 908 тоот
Утас: (976) 99055711, 99038602, 70005711
E-mail: dulguunhairhan_audit@mongol.net

2019.03.11 № 19/2-45

танай ____________-ны № ____________-т

**"НАКОТҮЛШ" ХК-ИЙН**
**УДИРДЛАГА-Д**

Аудитын тайлан, дүгнэлт,
зөвлөмж хүргүүлэх тухай

"Накотүлш" ХК болон "Дөлгөөнхайрхан уул Аудит" ХХК-ийн хооронд байгуулсан 18/2-44 дугаартай Аудитын үйлчилгээний гэрээ /хэлцэл/-г үндэслэн "Накотүлш" ХК-ийн 2018 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн тайланд аудит хийж, тайлан, дүгнэлт, зөвлөмжийг хүргүүллээ.

**Хүндэтгэсэн,**
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ: Б. ПҮРЭВДУЛАМ.

Scanned with CamScanner

ДӨЛГӨӨН ХАЙРХАН УУЛ
АУДИТ ХХК
Нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн
хөндлөнгийн хяналтын байгууллага
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороолол
Ногоон нуур гудамж, 101 барилгын 908 тоот
Утас: (976) 99055711, 99038602, 70005711
E-mail: dulguunhairhan_audit@mongol.net

2019.03.11 № 19/2-45

танай ________________-ны № ________________-т

"НАКОТҮЛШ" ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## Санхүүгийн тайлангийн аудит хийсэн тухай тайлан

### Хязгаарлалттай дүгнэлт

Бид "Накотүлш" ХК-ийн /цаашид "Компани" гэх/ 2018 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, *Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан асуудлуудын санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол*, "Накотүлш" ХК-ийн 2018 оны 12 сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайлангууд нь СТОУС-ын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартын дагуу бид хүлээх үүрэг хариуцлагынхаа энэхүү аудитын тайлангийнхаа Аудиторын үүрэг хариуцлага хэсэгт багтаан харуулсан. Бидний хувьд, санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Нягтлан бодогчдын ёс зүйн стандартын шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд бид эдгээр шаардлагын ёс зүйтэй холбоотой бусад үүрэг хариуцлагаа биелүүлсэн болно. Бидний олж авсан нотлох зүйл нь бидний дүгнэлтэд зохистой үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар Аж ахуйн нэгж, байгууллагад төлөх 1,829,416.0 мянган төгрөгийн өглөг, богино хугацаатай зээл, зээлийн хүүгийн 3,006,161.3 мянган төгрөгийн өглөг, Цаашид эдгээр өглөг нэмэгдэх магадлалтай. Тус компанийн үйл ажиллагаа нь зогссон байгаагаас уг өглөгүүд төлөгдөх боломжгүй бөгөөд бидэнд зээлийн гэрээ, хэлцэл, өглөгийн талаарх тодорхой мэдээлэл ирүүлээгүйгээс тулган баталгаажуулалт хийж чадаагүй болно.

### Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудлууд

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал үүссэн бөгөөд цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах талаар удирдлагаас тодорхой ажил зохиогоогүй, энэ талаар хийж байгаа зүйлс ажиглагдаагүй болно.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр, тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан, аудитын ажлын агуулга болон дүгнэлтийн хэлбэрт тусгалаа олсон бөгөөд эдгээр асуудал дээр бид тусад нь санал дүгнэлт гаргааүй болно.

Scanned with CamScanner

**Санхүүгийн тайланд засаглах удирдлага болон удирдлагын хүлээх үүрэг хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг бөгөөд энэхүү үүрэг, хариуцлагад аливаа алдаа, залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулахтай холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагууд багтана.

Ийнхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь компанийн тасралтгүй үргэлжлэх чадварыг үнэлэх, тодруулга гаргах, компаниа татан буулгах эсвэл үйл ажиллагааг нь зогсоох, өөр бусад арга хэмжээ авах зорилгогүй байгаа тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчмын үндэслэлийг ашиглах болон тухайн зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулга хэлбэрээр бэлтгэх зэрэг үүрэг хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

**Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний үүрэг, хариуцлага бол хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. АОУС-аар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй магадлалаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.
Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон санхүүгийн тайлангийн тодруулгыг нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажил орно. Аудитын явцад компанид хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолол, санхүүгийн тайлангуудын бодитой эсэхэд үнэлэлт өгөв.

Энэхүү тайлан нь Монгол улсын "Компанийн тухай" хуулийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болон хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид энэхүү Аудитын ажлыг хийж гүйцэтгэж аудитын тайланг бэлтгэсэн болно.

Б.ПҮРЭВДУЛАМ
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Scanned with CamScanner

*"Накотулш" ХК*

*Аудитлагдсан тайлан*

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

**2018 оны 12 сарын 31-ний байдлаар**

| | 2017 оны 12 сарын 31 | 2018 оны 12 сарын 31 |
|---|---|---|
| | | **(төгрөгөөр)** |
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | | |
| Авлага | 1,493,682.39 | 467,437.60 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 205,639,147.99 | 168,424,900.83 |
| Бараа материал | | |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 460,687,942.47 | 29,842,304.47 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | - | - |
| Бусад | | |
| **Нийт** | **667,820,772.85** | **198,734,642.90** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө (цэвэр) | 2,652,665,240.78 | 2,338,728,306.70 |
| Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | | |
| Биет бус хөрөнгө | 936,846.15 | 39,336.70 |
| **Нийт эргэлтийн бус хөрөнгө** | **2,653,602,086.93** | **2,338,767,643.40** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,321,422,859.78** | **2,537,502,286.30** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **Өр төлбөр** | | |
| Богино хугацаат өр төлбөр | 2,300,064,947.41 | 5,025,966,317.28 |
| Урт хугацаат өр төлбөр | 2,350,659,548.14 | - |
| **Нийт өр төлбөр** | **4,650,724,495.55** | **5,025,966,317.28** |
| **Эздийн өмч** | | |
| Дүрмийн сан | 1,261,572,100.00 | 1,261,572,100.00 |
| Халаасны хувьцаа | - | - |
| Нэмж төлөгдсөн капитал | 196,266,196.00 | 196,266,196.00 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1,583,766,766.54 | 1,359,590,704.54 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | - | - |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 2,780,000.00 | 2,780,000.00 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | (4,373,686,698.31) | (5,308,673,031.52) |
| **Нийт эздийн өмч** | **(1,329,301,635.77)** | **(2,488,464,030.98)** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ ДҮН** | **3,321,422,859.78** | **2,537,502,286.30** |

*Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

2019.03.11

Scanned with CamScanner

# ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

## 2018 оны 12 сарын 31-ний байдлаар

(төгрөгөөр)

| | 2017 оны 12 сарын 31 | 2018 оны 12 сарын 31 |
|---|---|---|
| **Борлуулалтын орлого (цэвэр)** | 212,252,545.94 | - |
| Борлуулалтын өртөг | 552,764,816.25 | - |
| **Нийт ашиг (алдагдал)** | **(340,512,270.31)** | - |
| Бусад орлого | - | - |
| Борлуулалт, маркетингийн зардал | - | - |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 528,972,191.15 | 337,386,369.10 |
| Санхүүгийн зардал | | |
| Бусад зардал | - | |
| Бусад олз (гарз) | - | 342,961.43 |
| Бусад ашиг (алдагдал) | 28,086,539.84 | 156,358,511.68 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **(897,571,001.30)** | **(494,087,842.21)** |
| Орлогын татварын зардал | | |
| **Татвар дараах ашиг (алдагдал)** | **(897,571,001.30)** | **(494,087,842.21)** |
| **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | | |
| **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **(897,571,001.30)** | **(494,087,842.21)** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | |
| **Орлогын нийт дүн** | **(897,571,001.30)** | **(494,087,842.21)** |
| **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)** | | |

*Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

2019.03.11

Scanned with CamScanner

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

**2018 оны 12 сарын 31-ний байдлаар**

**(төгрөгөөр)**

| | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2017 оны12 сарын 31** | 1,261,572,100.00 | 196,266,196.00 | 1,583,766,766.54 | 2,780,000.00 | (4,373,686,698.31) | (1,329,301,635.77) |
| өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | (440,898,491.00) | (440,898,491.00) |
| **Залруулсан үлдэгдэл** | 1,261,572,100.00 | 196,266,196.00 | 1,583,766,766.54 | 2,780,000.00 | (4,814,585,189.31) | (1,770,200,126.77) |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | (494,087,842.21) | (494,087,842.21) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | - |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | - |
| Зарласан ногдол ашиг | | | | | | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн | | | (224,176,062.00) | | | (224,176,062.00) |
| **2018 оны12 сарын 31** | **1,261,572,100.00** | **196,266,196.00** | **1,359,590,704.54** | **2,780,000.00** | **(5,308,673,031.52)** | **(2,488,464,030.98)** |
| | | | | | | - |

*Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

2019.03.11

*"Накотули" ХК* *Аудитлагдсан тайлан*

# МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## 2018 оны 12 сарын 31-ний байдлаар

(төгрөгөөр)

| | 2017 оны 12 сарын 31 | 2018 оны 12 сарын 31 |
|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **206,710,383.50** | **7,018,400.00** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого | 206,710,383.50 | 7,018,400.00 |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | |
| Буцаан авсан албан татвар | | |
| Татаас, санхүүжилтын орлого | | |
| Бусад мөнгөн орлого | | |
| **Мөнгөн зарлагын дүн** | **208,491,589.49** | **8,067,257.43** |
| Ажилчдад төлсөн | 133,793,379.00 | 3,600,000.00 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 13,500,000.00 | |
| Бараа материал худалдан авахад | 48,562,287.49 | 2,468,846.00 |
| Ашиглалтын зардалд төлсөн | | |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 3,987,735.28 | |
| Хүүний төлбөрт төлсөн | | |
| Татварын байгууллагад төлсөн | 2,268,955.91 | 67,350.00 |
| Даатгалын төлбөрт төлсөн | | |
| Бусад мөнгөн зарлага | 6,379,231.81 | 1,931,061.43 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,781,205.99)** | **(1,048,857.43)** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | - | - |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | |
| Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | | |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | |
| Хүлээн авсан хүүний орлого | | |
| Хүлээн авсан ногдол ашиг | | |
| **Мөнгөн зарлагын дүн** | - | - |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | |
| Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа | | |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | - | - |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | - | - |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| Төрөл бүрийн хандив | | |
| **Мөнгөн зарлагын дүн** | - | - |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | - | - |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | - | - |
| Төлсөн ногдол ашиг | | |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | (6,538.90) | 22,612.64 |
| Валютын ханшийн зөрүү | | |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(1,787,744.89)** | **(1,026,244.79)** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **3,281,427.28** | **1,493,682.39** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **1,493,682.39** | **467,437.60** |

*Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

2019.03.11

Scanned with CamScanner